




**МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**

Mongol Securities Exchange

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

2016 оны үйл ажиллагааны тайлан



| Агуулга

Бидний тухай

- Эрхэм зорилго
- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Байгууллагын бүтэц, орон тоо

Компанийн үндсэн үйл ажиллагаа

- Үнэт цаасны бүртгэл
- Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо
- Гишүүнчлэл
- Бусад

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа

- Санхүүгийн байдлын тайлан
- Орлого зардлын тайлан

Дүгнэлт

| Компанийн тухай

Монголын үнэт цаасны бирж нь 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор Дилерүүдийн арилжааны төв нэртэй байгуулагдсан.

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 312 тоот тогтоолоор Дилерүүдийн арилжааны төв ХХК-д “Үнэт цаасны арилжаа, тооцооны үйл

ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд энэхүү зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 08 дугаар сарын 26-ний өдрийн хурлын 15 тоот тогтоолоор компанийн оноосон нэрийг “Монголын үнэт цаасны бирж” болгон өөрчилж, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн.

| Эрхэм зорилго

Монголын үнэт цаасны биржийн эрхэм зорилго нь олон улсын стандартад нийцсэн биржийн үйлчилгээг нэвтрүүлж Монгол Улсын санхүүгийн захын хөгжлийг дэлхийн түвшинд хүргэхийн зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

| Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компани 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 357.0 сая ширхэг энгийн хувьцаа эргэлтэд гаргасан бөгөөд нийт хувьцааны 84.3 хувийг Даац инвестмент ХХК, 8.4 хувийг Даац менежмент ХХК, бусад 7.3 хувийг нэр бүхий 12 иргэн тус тус эзэмшиж байна.

| Төлөөлөн удирдах зөвлөл

Монголын үнэт цаасны биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) одоогоор 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга Н.Цогт

ТУЗ-ийн гишүүн М.Бат-оргил

ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэнэбат

ТУЗ-ийн гишүүн Т.Есүй

ТУЗ-ийн гишүүн Т.Болд

ТУЗ-ийн гишүүн Д.Жаргал

ТУЗ-ийн гишүүн Л.Энхтуяа


Компанийн дүрэмд заасны дагуу хараат бус 2 гишүүнийг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэр дэвшүүлэн сонгоно.

I Байгууллагын бүтэц, орон тоо

ТУЗ-ийн 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 14 тоот тогтоолоор компанийн бүтцийг шинэчлэн баталсан (зураг 1).

Нийт 25 орон тоотой ажиллахаас 2016 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан орон тооны 14 мэргэжилтэн, санхүүгийн

зах зээлд ажиллаж байсан туршлагатай гэрээт 7 мэргэжилтэн, нийт 21 хүн ажиллаж байна. Мэргэжилтнүүдийн 92.8 хувь нь дээд боловсролтой, үүнээс 85,7 хувь нь бакалаврын, 14.3 хувь нь магистрын зэрэгтэй, 78.6 хувь нь санхүү эдийн засаг бизнесийн удирдлагын, 14.3 хувь нь мэдээллийн технологийн, 7,1 хувь нь инженерийн боловсролтой.



Зураг 1. Монголын үнэт цаасны биржийн бүтэц зохион байгуулалт

КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын үнэт цаасны бирж нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 312 тоот тогтоол, ТҮЗ-аас өгөгдсөн үүргийн дагуу үндсэн үйл ажиллагааны дүрэм журам боловсруулан батлуулах, гишүүн үнэт цаасны компани элсүүлэх, программ хангамж хүлээн авах, турших, суурилуулах, хүний нөөц бэлтгэх, үйл ажиллагаагаа танилцуулах, үнэт цаас гаргах сонирхолтой бизнесийн

байгууллагуудтай уулзах, үнэт цаас гаргахад нь туслах, бүртгэлийн өргөдөл хүлээн авч хянах чиглэлээр 2016 онд үйл ажиллагаагаа төлөвлөн явуулаа.

Тайлант хугацаанд ТҮЗ-ийн хурал 10 удаа хуралдаж, давхардсан тоогоор нийт 37 асуудлыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргасан байна.

Үнэт цаасны бүртгэл

Үнэт цаасны бүртгэлийн дүрэм журам, заавар, удирдамж, маягт боловсруулан батлуулах, батлагдсан дүрэм журмыг гишүүд, бизнесийн байгууллагууд болон сонирхогч бусад этгээдэд танилцуулах, аудит, үнэлгээ, хуулийн зөвлөх үлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт явуулах, үнэт цаасаа бүртгүүлэх, бүртгэлийн зарим шалгуураас чөлөөлүүлэх тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх, бүртгэлийн баримт бичгийн эхний төслийг хүлээн авах, Бүртгэлийн хороо байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулаа. Эхний хагас жилд үнэт цаасны бүртгэлтэй холбоотойгоор нийт 2 журам, 2 удирдамж, 11 маягт, 5 загвар боловсруулан батлуулж үнэт цаас гаргагч болон мэргэжлийн оролцогчдын эрх үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Үнэт цаасаа бүртгүүлэх, бүртгэлийн зарим шаардлагаас чөлөөлүүлэхээр ирүүлсэн хүсэлтийг хянан зохих шийдвэрүүдийг гаргасан болно. Үүнд:

- “Эко хавтан” ХХК-иас 2016 оны 03 сарын 16-ны өдөр бүртгэлийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт, 2016 оны 03 сарын 31-ний өдөр үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг тус тус ирүүлсэн бөгөөд бүртгэлийн шалгалтын явцад “Эко хавтан” ХХК-ийн төслийн тооцоолол алдаатай, бүртгэлийн шалгуурыг хангаагүй тул бүртгэлийн үйл ажиллагааг зогсоосон.

- “Хурниад” ХХК-иас 2016 оны 05 сарын 18-ны өдөр бүртгэлийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэн бөгөөд тус компанийн бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой холбогдуулан бүртгүүлэх үйл ажиллагааг хойшлуулсан.

- 2016 оны 12 дугаар сард Монголын үнэт цаасны бирж дээр үнэт цаасаа гаргах сонирхолтой 3 компанийн хүсэлтийг хүлээн авч үнэт цаас бүртгүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

I Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо

Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны үйл ажиллагааг зохицуулах үндсэн журмуудыг батлах, мэдээллийн нэр төрөл, урсгал, хадгалалтыг зохицуулсан загвар, маягтууд боловсруулах, арилжааны болон тооцооны гишүүд, зах зээл үүсгэгч, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, харилцагчидтай байгуулах гэрээний загвар батлах, арилжаа, тооцооны үйл ажиллагааны дэлгэрэнгүй заавар аргачлал гаргах, Биржээс гаргах мэдээ мэдээллийн загвар бэлтгэх, арилжаа, тооцооны үйл ажиллагааны программ

хангамжийг хүлээн авч, турших, сервер, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулах, гишүүдэд сургалт явуулах ажлуудыг гүйцэтгэлээ.

Тооцооны гишүүн элсүүлэхтэй холбоотой Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Капитрон банк, Төрийн банк, Очир ундраа инвестмент ББСБ, Номин холдинг, Чингис хаан банк зэрэг байгуулагуудтай уулзалт зохион байгуулж холбогдох судалгаа танилцуулгыг хүргүүлээ.

I Гишүүнчлэл

“Монголын үнэт цаасны биржийн гишүүнчлэлийн журам”-ын дагуу эхний хагас жилд 7 үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлж одоогийн байдлаар Дэлгэрхангай секюритиз, Монсек, Батс, Гаули, Зэргэд, Превалент, Эф Си Икс, Бумбат алтай, АСЕ энд Т капитал, Булган брокер, Лайфтайм инвестмент зэрэг нийт 11 үнэт цаасны компани Монголын үнэт цаасны биржийн гишүүнчлэлтэй болоод байна.

Гишүүнээр элссэн компаниудад биржийн зохицуулалт, үйл ажиллагаа, гишүүнчлэл

болон хяналтын журмын талаар сургалт зохион байгуулав. СЗХ-оос андеррайтерийн эрх авсан 22 компанид бүртгэлийн журам, бүртгэлийн процесс, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа болон IPO хийх боломжит төслүүдийн танилцуулга сургалт зохион байгуулсан. Мөн гишүүнээр элсэхийг сонирхож буй компаниудтай уулзалт хийх, мэдээлэл өгөх зэргээр ажиллаж байна.

Цаашид цахим хуудсаар гишүүнчлэлийн өргөдөл хүлээн авахаар вэб хуудас захиалан хийлгэж ашиглахад бэлэн болоод байна.

I Бусад

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын нөлөөллийн матриц, өрсөлдөгчийн судалгаа, амжилтад нөлөөлөх түлхүүр зүйлсийн шинжилгээ, нөөцийн шинжилгээ, SWOT анализ, зах зээлийн багтаамжийн судалгаа хийж маркетингийн зорилго, зорилт, стратегийг тодорхойллоо.

Байгууллагын вэб хуудас захиалан хийлгүүлж эхний байдлаар хүлээн авсан, одоогоор найруулгыг бүхэлд нь хянах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт ажилбаруудыг оруулах ажил хийгдэж байна.

Хэвлэл мэдээллийн байгуулагуудтай хамтран

ажиллах, үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах, компанийн танилцуулгыг монгол, англи хэлээр бэлтгэх, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах эхлэлийг тавьлаа.

“Монголын үнэт цаасны биржийн дотоод журам”; “Захирлын зөвлөлийн ажиллах журам”, “Ажилтан сонгон шалгаруулж авах журам”, “Ажилтны ёс зүйн дүрэм”, “Нууц

хамгаалах, нууц баримт бичигтэй ажиллах журам”, “Үйлдлийн систем, хэрэглээний программ хангамжийн хэвийн аюулгүй ажиллагааны стандарт”, “Монголын үнэт цаасны биржийн албан хэрэг хөтлөлтийн заавар”, “Монголын үнэт цаасны биржийн дотоод хяналтын журам” зэрэг баримт бичгүүдийг боловсруулан баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 10 дугаар сард газар дээрх хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн тайлан хүргүүлээд байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа

Тайланд онд балансын нийт хөрөнгийн дүн 4.7 тэрбум төгрөгт хүрснээс 307.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 4.45 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө бүртгэлтэй байна (Хүснэгт 1). Эргэлтийн бус хөрөнгөд 44.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 4.41 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Компанид 2016 онд шинээр оруулсан 2.98 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгө оруулалтыг хараат бус үнэлгээний байгууллагаар үнэлүүлэн балансад бүртгэсэн. Мөн 2015 онд гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн “Арилжаа, төлбөр тооцооны цогц программ хангамж”-ийг актаар хүлээн авч, хөрөнгөөр хүлээн зөвшөөрөн бүртгэсэн бөгөөд уг худалдан авалттай холбоотой

төлбөрийн үлдэгдэл 650.0 сая төгрөгийн өр төлбөр тайлангийн эх үүсвэр талд тусгасан болно.

Хөрөнгийн эх үүсвэр талд богино хугацаат өр төлбөр 1.1 тэрбум төгрөг, эздийн өмч 3.7 тэрбум төгрөг, нэмж төлөгдсөн капитал 360.5 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 231.0 сая төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг 70.0 сая төгрөг, хуримтлагдсан алдагдал 660.0 сая төгрөг тус тус бүртгэгдлээ.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн хураангуй (Аудитлагдсан)

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2016.01.01-ний үлдэгдэл	2016.12.31-ний үлдэгдэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1.67	16.29
2	Авлага	60.99	76.65
3	Бараа материал	1.88	1.76
4	Урьдчилж төлсөн зардал	500.00	212.18
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	564.55	307.01
6	Үндсэн хөрөнгө	59.82	44.00
7	Биет бус хөрөнгө	-	4,410.00
8	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	59.82	4,454.00
	НИЙТ ХӨРӨНГӨ	624.37	4,760.89
9	Цалингийн өглөг	5.41	103.04
10	Татварын өглөг	4.67	19.99
11	ХХОАТ-ын өглөг	8.02	42.19
12	Бусад богино хугацаат өр төлбөр	20.00	923.68
13	Богино хугацаат өрийн дүн	38.10	1,088.91
14	Өмч: Хувийн	357.05	3,670.50
15	Нэмж төлөгдсөн капитал	494.95	360.50
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	231.0
17	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	70.00
18	Хуримтлагдсан ашиг	(265.73)	(660.02)
19	Эздийн өмчийн дүн	586.27	3,440.98
	НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	624.37	4,760.89

Богино хугацаат өрийн дүнд дансны өглөг 26.2 сая төгрөг, цалингийн өглөг 103.0 сая төгрөг, татварын өр 19.9 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл төлбөр 42.2 сая төгрөг, программ хангамжийн төлбөрийн үлдэгдэл 650.0 сая төгрөг, бусад өглөг 247.5 сая багтаж байна.

Тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардалд 394.3 сая төгрөг зарцуулсан байна.

I Дүгнэлт

Өнгөрсөн 2016 онд үндсэн үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлууд хийгдэж, хүний нөөц, дүрэм журам, гишүүн байгууллагууд, программ хангамжийн асуудлуудыг шийдвэрлэн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 3.6 тэрбум төгрөгт, компанийн нийт хөрөнгийг 4.7 тэрбум төгрөгт хүргэн нэмэгдүүлэн 216 онд тавьсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүллээ. Эхний компаниуд Биржийн дүрэм журмыг хүлээн зөвшөөрч, үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах сонирхлоо илэрхийлээд байгаа нь өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд манай байгууллагын үйл ажиллагаа эрэлттэй байгааг харуулж байна. Хэдий тийм боловч хөрөнгийн захын тухай олон нийтийн ойлголт мэдлэг бага, мэргэжлийн зуучлагч байгууллагуудын ашиг орлого, үйл ажиллагаа буурсан, бизнесийн байгууллагуудын засаглалын стандартын хэрэгжилт сул зэргээс шалтгаалан сонирхогч этгээдүүд Биржийн бүртгэлийн шалгуурыг хангахад хүндрэл үүсэх, хугацаа алдах, гишүүн байгууллагууд шинэ зохицуулалт, шинэ үйлчилгээг болгоомжлох, харзнах байдлаар хүлээн авах зэрэг бэрхшээлүүд гарсаар байна.

Цаашид үйл ажиллагаагаа сурталчлах, идэвхжүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Хорооны журмын шалгуурт нийцүүлэн нэмэгдүүлэх,

тооцооны гишүүн элсүүлэх, зах зээл үүсгэгчтэй гэрээ байгуулах, back office системийг гишүүдэд нэмж суурилуулах, анхан шатны баримт бичгүүдийн загварыг шинэчлэн батлах, Хороогоор батламжлуулсан үндсэн журмуудын хүрээнд илүү нарийвчилсан зохицуулалтууд буюу үйл ажиллагааны журмуудыг батлуулах, үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн компаниудын бүртгэлийн өргөдлийг хүлээн авч хянах, 6-аас доошгүй компанийн үнэт цаасыг бүртгэн арилжихаар төлөвлөж байна.

2017 онд нийт 28 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийх, үндсэн ажиллагаа эхлүүлсний дараа хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гарган санхүүжилт татах, хувьцаа худалдсаны орлого болон үйл ажиллагааны орлогоос урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх, 2018 оны эхээр компани өөрийн үнэт цаасыг олон нийтэд санал болгох, энэ орлогоор NASDAQ группийн систем нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна.

| Холбоо барих

ЗАХ ЗЭЭЛ ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА

Үнэт цаасаа бүртгүүлэх, гишүүнээр элсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө авах

Утас: +976-7000 0502
И-мэйл: adiyasuren@msx.mn

АРИЛЖАА, СИСТЕМИЙН УДИРДЛАГЫН АЛБА

Үнэт цаасны арилжааны хуваарь, арилжааны журмын талаарх мэдээлэл авах

Утас: +976-7000 0501
И-мэйл: baasandavaa@msx.mn

ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АЛБА

Тооцооны үйл ажиллагаа, маржин барьцаа байршуулах талаар мэдээлэл авах

Хаяг:

703 тоот, GB Плаза, 8-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Монгол Улс